# Гарчиг

1. Товч тодорхойлолт ........................................................................................................ 3
2. Төсөл хэрэгжүүлэж буй ордын байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдал ........ 4
3. Байгаль орчин менежментийн тайлан ........................................................................ 6
4. Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний тайлан ..................................................... 7
5. Нөхөн сэргээлтийн тайлан ........................................................................................ 10
6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний тайлан ................................................................. 12
7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний тайлан ................................ 13
8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний тайлан .................................................... 13
9. Химийн бодисийн эрсдлийн менежментийн тайлан ........................................................ 14
10. Осол эрсдлийн менежментийн тайлан ......................................................................... 15
11. Хог хаягдалын тайлан ................................................................................................. 19
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ......................................................................... 21
13. Удирдлага зохион байгуулалтын тайлан ....................................................................... 22
14. Байгаль орчин менежментийн тайлан хэрэгжүүлэх хуваарь............................................. 24
15. Ашигласан материал

**Хавсралт материал**

Зураг 1 Төсөл хэрэгжих талбайн байршлын тойм
Зураг 2 Төслийн талбай
Зураг 3 Тээврийн маршрут
Зураг 4 Сөрөг нөлөөлөлийг бууруулахаар хийсэн ажлын зургууд
Зураг 5 Биологийн нөхөн сэргээлт
Зураг 6 Моджуулсан талбай
Зураг 7 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
Зураг 7 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
Зураг 23 ХАЛМ-ийг шаардлагатай газруудад байршуулсан байдал
Зураг 27 Уурхайн давтан зааварчилгааны дадлага

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбилцлууд
Хүснэгт 2 Байгаль орчин менежментийн тайлангын нийт зардал
Хүснэгт 3 Байгаль орчны сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ
Хүснэгт 4 Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ
Хүснэгт 5 Байгаль орчны нөхөн сэргээлт
Хүснэгт 6 Дүйцүүлэх арга хэмжээ
Хүснэгт 7 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний тайлан
Хүснэгт 8 Осол, эрсдэлийн менежментийн тайлан
Хүснэгт 9 Хог хаягдалын менежментийн тайлан
Хүснэгт 10 Удирдлага зохион байгуулалт
Хүснэгт 11 Орон нутгийн иргэдэд танилцуулга

# ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Төслийн нэр :** "Ширээ Уул" 2 гөлтгөний ордыг ил аргаар ашиглах төсөл
**Төслийн хүчин чадал :** Жилд 60.0 мян.тн гөлтгөнө олборлох хүчин чадалтай
**Байршил :** Дундговь аймаг Дэлгэрхангай сум
**ААНХаяг :** Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо,
Бага тойруу 19-32 тоот, Утас:91915410
**Хариуцах хүн :** Байгаль орчны мэргэжилтэн Д. Цэнд-Аюуш
Утас : 89102512
**БОНБНҮ-ний батлагдсан огноо :** БОНБНҮ-г Байгаль орчны судалгаа, үнэлгээний
"Хос Санаа" ХХК 2018-06-20 N13/6611

**Төсөл хэрэгжих талбайн байршлын тойм** *зураг 1*




"Ширээ Уул" 2 гөлтгөний орд нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урд зүгт 460км, Дэлгэрхангай сумын төвөөс баруун урагш 50 км-т тус тус байрлана. Дэд бүтцийн хувьд сул хөгжсөн ба Улаанбаатар Өмнөговь чиглэлийн хатуу хучилттай авто замаас 120км зайтай оршдог.

# ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Төслийн нэр

“Ширээ Уул” 2 гөлтгөний ордыг ил аргаар ашиглах

## Төслийн зорилго

Төсөл хэрэгжүүлэгч “Түмэн Цацал” ХХК нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Ширээ Уул” 2 гөлтгөний ордыг Монгол улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэй уурхайн үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар ханган, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

**Төслийн талбай /Google earth/** *Зураг 2*



- Ордын нэр: “Ширээ уул-II” гөлтгөний орд
- Засаг захиргаа: Дундговь аймаг, Дэлгэрхангай сум
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Гөлтгөнө
- Тусгай зөвшөөрлийн талбайн планшет: L-48-101
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ: 31. 98 га.

**Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицлууд** *Хүснэгт № 1.*

| Цэгийндугаар | Талбайн солбицлууд | Газарзүйн солбицлын систем | | | Метрийн солбицлын систем /UTM/ | | Талбай |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Град | Мин | Сек | | | |
| 1 | Уртраг | 104 | 20 | 47. 11 | Y | 448,472. 167 | |
| | Өргөрөг | 44 | 58 | 56. 97 | X | 4,981,213. 204 | 31,98 га |
| 2 | Уртраг | 104 | 20 | 20. 11 | Y | 447,880. 872 | |
| | Өргөрөг | 44 | 58 | 56. 97 | X | 4,981,217. 999 | |
| 3 | Уртраг | 104 | 20 | 20. 11 | Y | 447,885. 284 | |
| | Өргөрөг | 44 | 59 | 14. 5 | X | 4,981,758. 931 | |
| 4 | Уртраг | 104 | 20 | 47. 11 | Y | 448,476. 310 | |
| | Өргөрөг | 44 | 59 | 14. 5 | X | 4,981,754. 138 | |

## УУРХАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Ширээ Ул 2” ордын MV-016920 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын кадастрын хэлтэсийн даргын 2010 оны 09-р сарын 28-ны өдрийн 0990 тоот шийдвэрээр 30 жилийн хугацаатай “Түмэн Цацал” ХХК -д олгосон байна. Уг зөвшөөрлийн талбай нь Дэлгэрхангай сумын “Ширээ Ул 2” нэртэй газар 31,98 га талбайг хамардаг.

“Ширээ Ул 2” гөлтгөний ордын ТЭЗҮ-г УУХҮЯ болон АМГТГ-ын ЭБМЗ -өөр 2018. 07. 18 өдөр хэлэлцэж дугаар Т/18-08-07 тоот дүгнэлтийг гаргасан. Энэ дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2018. 08. 01 өдөр дугаар Т/80 тоот тушаалаар “Ширээ Ул 2” гөлтгөний ордын нөөцийг II-IVхайгуулын шугамын хоорондын нөөц МҮ-016920 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл талбайд хамрагдахнөөц $C_2$ зэргээр гөлтгөнө 258,82 мян/тн конкрецид 1263,68 мян/тн шавар дахь гөлтгөнө 74,25 мян/тн буюу нийт 1596,75мян/тн нөөц бүртгэсэн.

## БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭЛТИЙН МАРШРУТ

Бүтээгдэхүүн тээвэрлэх замын маршрутыг мөрөн ажиллаж байна.Тус замыг шинэчлэх маршрутыг Дэлгэрхангай сумын иргэдийн хурлаар өөрчилөх саналыг аймаг ИТХ санал оруулахаар зөвшилцөн төв зам дагуу тэмдэг тэмдэглэгээг сайжруулан нэмэгдэл тэмдэг тавьсан.

**Тээврийн замын маршрут** *Зураг 3*




Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замд хяналт тавьж маршрутын зөвшөөрөгдөх замаар хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах тээвэрлэх зам дагуу гөлтгөнө асгахгүй байх олон салаа зам гаргахгүй байхад анхаарч хяналт тавьж ажилласан.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Энэхүү байгаль орчныг хамгаалах тайлан /БОМТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Түмэн цацал” ХХК -аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖС-ын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу “Ширээ Уул 2” гөлтгөний ордын ил уурхайн аргаар ашиглах төсөлийн үйл ажиллагааны явцад авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн тайланг боловсруулав. 2024 оны Байгаль орчин менежментийн тайлангын нийт зардал 44,69 мян.төгрөг төсөвлөн хэрэгжүүлсэн.

Байгаль орчин менежментийн тайлангын гол зорилго

2024 оны байгаль орчин менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Ширээ Уул-2” гөлтгөний ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон цаашид учруулаж болзошгүй сөрөг нөлөөлөлийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

**БОМТ-ний зардал** *Хүснэгт 2.*

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | | Нийт зардал (сая.төг) |
|---|---|---|---|
| 1 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө | 1,81 |
| 1.1 | | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 21,8 |
| 1.2 | | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | 2.3 |
| | | Химийн бодис эрсдлийн менежментийн төлөвлөгөө | |
| 1.3 | | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 6,3 |
| 1.4 | | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 3,0 |
| 1.5 | | Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | 9.03 |
| 2 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 0.45 |
| **Нийт зардал** | | | **44,69** |

## СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөж болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход тухайн төслийн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, амьтаны аймаг, агаар орчинд сөргөөр нөлөөлөнө . Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр сөрөг нөлөөллийг зохих түвшинд нь байлгах бүрэн боломжтой

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн ажиллагааны талаар тайлагнав.

Агаар , хөрс, ургамал усан орчин зэрлэг амьтаны эко системийг хамгаалахад хийгдсэн ажилууд

Төсөлд ашиглагдах бүх төрлийн тээврийн хэрэгслийг улсын үзлэг оншилгоонд хамруулснаар тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж хяналт тависнаар аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэхээс гадна ШМТ асгарах байгаль орчин бохирдохоос сэргийлэж чадсан.

Агаарт ялгарах хорт хий болон утааг стандарт шаарлагат нийцүүлэн асалт болон хөдөлгүүрийн системд тогтмол хяналт тавьж үйлчилгээг цаг тухай нь хийсэн.

Төслийн талбайд замын хөдөлгөөний эргэлтийн хэсэгт хайрга дэвсэж тоосжилттой эх үүсвэрт хусаж тэгшлэх усалгаа хийх зэрэгээр хамгаалдаг.

Хүнд даацын машин техникийн хөдөлгөөнөөс үүсгэх уурхайн замыг засаж янзалсан.

Шимт хөрс болон хөрсөн давхаргыг овоолгыг стандартын дагуу хийсэн.

Хөрсний шинж чанрыг алдагдуулахгүйн тулд орчин бохирдлоос хамгаалаж цэвэрлэгээг тогтмол хийсэн.Дотоод овоолго болон гадаа овоолгыг салхины чиглэл болон стандартыг хангаж ажилласан.

**Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** *Хүснэгт 3.*

| Бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Нэгжийн өртөг /мян.төг/ |
|---|---|---|
| **Хөрсөн болон Ургамалын бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл** | | |
| Тоосжилтын эх үүсвэрийг хусаж авч хайрга асгаж янзалсан уурхайн замыг засаж янзалсан | Төслийн талбайд | Үйл ажилгааны зардалд тусгасан |
| Тээврийн хэрэгслийн үзлэг оншилгоо<br>Засвар үйлчилгээ тогтмол хийсэн | Төслийн хүрээнд | Үйл ажилгааны зардалд тусгасан |
| Уурхайн талбайн эмх цэгцийг засаж янзалсан агаар усны шинжилгээ хийлгэсэн<br>Усны дүгнэлт гаргуулсан | Төслийн талбайд | 1,495 |
| Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замын үер усанд эвдэрсэн хэсгийг янзалсан. | Төслийн талбайн ойролцоо | 315,0 |
| **НИЙТ** | | **1810,0** |

*Зураг 4*



*Техникийн оншилгоо*

*Зураг 5*




*Урьдчилсан үзлэг оншилгоо*

*Зураг 6*



*Усалгаа*

*Зураг 7*



*Усны дүгнэлт*

*Зураг 8*




*Усны төлбөр*

**Ургамалан бүрхүүлд гарах сөрөг нөлөөлөлийг бууруулах арга**

Уурхайн үйл ажиллагаанаас болон хөрс ургамлын бүтэцэд өөрчлөлт орж ургах чадварт муугаар нөлөөлөх нөхцөл бүрдэх үүнээс урьдчилан сэргийлэж хэрэгжүүлсэн арга хэмжээ

Үр үрсэлгээгээр нутгийн ургамлыг шилжүүлэн суулгасан

Үрийн түүж хадгаласан

Ургамлын ургалтыг сайжруулах ажил хийсэн./байгалийн бордоогоор бордсон/

Худгийн усыг үер уснаас хамгаалах ажил хийсэн.

Зэрлэг амьтадын амьдрах орчин нөхцлийг хамгаалаж

Хавар эцэж ядарсан зэрлэг амьтанд идэш тэжээл тавьж өгөх ажлын хүрээнд байгаль хамгаалагч нарт зэрлэг амьтанд тавьж өгөх өвс тэжээлийн туслалцаа үзүүлсэн

Дэлгэрхангай ууланд хөв цөөрөм хийхэд цөөрмийн дор ус тусгаарлагчаар ордог пилёнкний туслалцаа үзүүлсэн

**Сөрөг нөлөөлөлөөс урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ**

*Хүснэгт 4*

| Сөрөг нөлөөлөлийг бууруулахаар хийгдсэн ажил | Хамрах хүрээ |
|---|---|
| Зэрлэг амьтанд 50 боодол өвс тэжээл тавиж өгөх | Дэлгэрхангай ууланд |
| Хөв цөөрөм байгуулах<br>Пилонк матриалын туслалцаа үзүүлсэн | Дэлгэрхангай ууланд |
| Зуданд осгож үхсэн малын сэг зэмийг нүх ухаш булшилсан | Төслийн талбайн ойролцоо |

Ургамлын уургалтыг харуулсан *Зураг 9* *зураг 10*




*Зэрлэг амьтанд өвс тэжээл тавьж өгч байгаа байдал*



*Хөв цөөрөм хийсэн байдал*

**Нөхөн сэргээлт**

**Төслийн талбайд техникийн нөхөн сэргээлт**

Олборлох үйл ажиллагаанаас үүссэн 0,9 га талбайд техникийн нөхөн сэргээлийг дотоод овоолго 0,4 га талбайд, 30,0 мян. $м^3$ дүүргэлтийг стандартын дагуу хийсэн 0,4 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг нутгийн ургамлаар баяжуулан хийсэн

*Хүснэгт 5*

| № | Байгаль Орчны нөхөн сэргээлт | Гүйцэтгэл | Хэмжих нэгж | Нэгж үнэ сая.төг |
|---|---|---|---|---|
| 1 | Техникийн нөхөн сэргээлт/ гадаад/ | 0,2 | 2,0 | 1,6 |
| 2 | Техникийн нөхөн сэргээлт/ дотоод/ | 0,4 | 30,0 | 15,7 |
| 3 | Биологийн нөхөн сэргээлт /шимт хөрс/ | 0,4 | 2,0 | 1,5 |
| 4 | Биологийн нөхөн сэргээлт | 0,4 | | 2,0 |
| 5 | Биологийн олон янз төрлийн ургамал | | 300ш | 1,0 |
| | **Нийт зардалд** | | | **21,8** |

Шимт хөрсний дүүргэлтийг 0,2 га талбайд 2,0 мян.$м^3$ хөрс тэгшилж таарсан. шимт хөрсний дэлгэлт тэгшилгээ стандартын дагуу хийсэн.

**Биологийн нөхөн сэргээлт**

Биологийн нөхөн сэргээлтийн нийт 0,4 га талбайд хийсэн Үүнд :

0,2 га талбайд биологийн олон янзын нутгийн ургамалын үр болон шилжүүлгээр /тана бударгана баглуур / гэх мэт суулгасан. 0,2 га талбайд байгалийн олон янз төрлийн ургамал тарьсан ургамалын дундаж өндөр нь 15-45 см өндөртэй ургамлын ургалт 80% байна.

**Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн ерөнхий байдал**

*Зураг 11*



*Зураг 12*



Хялгана, бударгана, баглуур түлхүү ургасан.

0,2 га талбайд хармаг бут 300ш суулгаж усалгаа арчилгааг тогтмол хийсэн

түрүүчийн тарьсан улаан сухай ургалт сайн байгаа.

**Моджуулсан талбай**

*Зураг 13*



Улаан сухай

*Зураг 14*



Хармагын бут

*Зураг 15*



*Зураг 16*



*Хармаг жимс*

*Зураг 17*



*Бажу*

*Зураг 18*



*Заг*

**Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний**

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд сум орон нутгийн байгуулагатай тохиролцон Дэлгэрхангай ууланд зудтай хүнд нөхцөлд зэрлэг амьтаны идэш тэжээл бэлтгэхэд туслан 50 боодол өвсийг сумын байгаль хамгаалагч нарт хүлээлгэж өгсөн.

- Мөн ууланд хөвд цөөрөм хийхэд ус нэвтэрдэггүй пленка авч өгсөн
- Халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэж уурхайн ойролцоо амьдардаг малчин иргэдийн зуданд осгож үхсэн малын сэг зэмийг нүх ухаж булшилсан
- Үерийн усанд эвдэрсэн 0.1 га талбайг түрж тэгшилсэн

**Дүйцүүлэх арга хэмжээ** *Хүснэгт 6*

| № | Байгаль орчны нөхөн сэргээлт | Хамрах хүрээ | Нэгж үнэ |
|---|---|---|---|
| 1 | өвс | Дэлгэрхангай ууланд | 500,0 |
| 2 | Хөв цөөрөм | Дэлгэрхангай ууланд | 900,0 |
| 3 | Үерт эвдэрсэн газар зам засвар | Дэлгэрхангай сум2-р багийн нутагт | 900,0 |
| | **Нийт** | | **2300,0** |

*Зураг 19*




*Дэлгэрхангай ууланд өвс тарааж байна*

*Зураг 20*



*Дэлгэрхангай хийсэн хөв цөөрөм*

*Зураг 21*



*Зураг 22*



*Дэлгэрхангай сумын 2-р багийн нутагт зам засаж байна.*

**Нүүлгэн шилжүүлэх ажил**

“Шируу Уул 2” гөтгөнө ил уурхайн аргаар ашиглах төсөл-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн МҮ-016920 дугаартай талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй.

## ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Газар шорооны ажлын үед өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй. Иймд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 27.8-д хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргасан.

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах МУ-ын хууль эрх зүйн орчныг дагаж мөрдөх
- Түүхийн болоод соёлын өв сангийн зүйлүүд олдох буюу магадлал ихтэй бол нэн даруй төслийн үйл ажиллагааг зогсоож, орон нутгийн засаг захиргаа мөн улс төрийн болон холбогдох шинэчлэх ухааны судалгааны байгууллагуудад мэдэгдэх
- Түүх, соёлын дурсгал болон ард түмний зан үйлд харшлах зүйлийг хөндөхгүй байхын үүднээс талбайд орших дурсгалт зүйлст хамгаалалт хийх, ойр орчмоор нь машин техник явуулахгүй байхаар зохион байгуулна.

Байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд архелоги, палеонтлоги, түүх соёлын дурсгалт зүйлс бүртгэгдээгүй болно.

2024 онд үйл ажиллагаа явуулаж буй талбайд архелоги, палеонтлоги, түүх соёлын дурсгалт зүйлсийн илрээгүй болно. Тиймээс энэ чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээ авагдаагүй.

**Эрх зүйн хязгаарлалт:**

МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон ЮНЕСКО-гоос баталсан олон улсын эрх зүйн актуудад соёлын төрөл зүйл, соёлын өвийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг тодорхой тусгасан байдаг. Үүнд:

- 1972 онд баталсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах” тухай конвенц;
- 2001 онд баталсан “Соёлын төрөл зүйлийн тухай” тунхаглалд соёлын өв, түүний төрөл зүйл нь бүх хүн төрөлхтний өв хөрөнгө бөгөөд өнөө үе болон хойч үеийн ашиг сонирхлын үүдсэнээс тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хадгалж хамгаалах тухай заасан байна;
- МУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 7.1-д “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан;

МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-д хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи,

угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна. 27.9-д урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна. 27.10-т урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно гэж заажээ;

Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байх бөгөөд соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

*Хүснэгт 7*

| **Хамгаалах арга хэмжээ** | **Арга хэмжээний Хамрах хүрээ** | **Баримтлах стандарт , аргачлал** |
|---|---|---|
| Олдвор илэрвэл тухайн үед нь орон нутгийн захиргаанд мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах | Төслийн талбайд | Соёлын өвийг хамгаалах тухайн хуулийн 23.1,27.8,38.3 зэрэг заалтууд |

Шаарлагатай нөхцөл үүссэн үед төсөв зохиож хэрэгжүүлнэ.

**Химийн бодисын эрсдлийн менежментийн тайлан**

“Ширээ Ул 2” гөлтгөнийг ил уурхайн аргаар ашигладаг
Төсөлийн талбайд химийн бодис ашигладаггүй.

**Осол, эрсдэлийн менежментийн тайлан**

Төслийн талбайд ажиллаж байгаа нийт ажилчидад аюулгүй ажиллагааг хангаж сургалт зөвлөмж тогтмол өгдөг.

- Санамсар болгоомжгүй байдлаас болж гал гарах бэртэж гэмтэх нөхцөлөөс сэргийлэж санамж зөвлөгөө зааварчилгаа өгдөг.
- ШТМ-ын ойролцоо болон төхөөрөмж дээр галын хор байршуулсан.
- Гал утрах хэрэгслийн бэлэн байдлыг хангуулсан.
- Галын хортой зөв харьцах талаар сургалт зохион байгуулсан.
- Галын самбар, сараатай болсон
- Ажилчдын аюулгүй байдлыг хангах
- Ажлын хувцас хэрэглэлээр хангасан ажлын туслах материал хэрэглэгдэхүүнийг хангасан
- Гэнтийн ослын үед хэрэглэх анхан шатны тусламж үзүүлэхэд эмийн санг нэгж бүрт олгосон

Төслийн талбайд хөдөлмөр аюулгүй ажиллагааны лавлах мэдээлэлийн самбар болон осол эрсдлийн үед анхан шатны туслалцаа үзүүлэх талаар мэдээлэлийн самбарыг ажлын байранд байршуулав.

ХАЛМ-ийг шаардлагатай газруудад байршуулсан байдал

*Зураг 23* *Зураг 24* *Зураг 25* *Зураг 26*









Уурхайд ашиглаж буй ШТМатериал бүтээгдэхүүн, тэдгээрийн шинж чанар яаж зөв зохистой хэрэглэх талаар сургалтаар дамжуулан мэдээлэл өгсөн.

ШТМ-ын аюулгүй байдал, хор аюулын лавлах мэдээлэлтэй танилцах” сэдвийн хүрээнд уурхайн засварын хэсэгт ажиллаж байгаа бүх ажилчдад давтан зааварчилгаа танилцуулаж дадлагжуулдаг.

*Зураг 27* *Зураг 28*




*Аюулгүй ажиллагааны талаар сургалт дадлага хийж буй байдал*

**Осол, эрсдэлийн менежментийн тайлан** *Хүснэгт 8*

| **Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл** | **Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ** | **Арга хэмжээний цар, хэмжээ** | **Нийт зардал /мян.төгрөг/** |
|---|---|---|---|
| Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх урьдчилан сэргийлсэн | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн<br>Гал унтраах хэрэгслээр ханган ажилласан<br>Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар урьдчилан таниулсан | Төслийн талбайн техник тоног төхөөрөмжид<br>Уурхайн хэмжээнд | 500.0 |
| Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажилдаг | Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах | Үйл ажиллагааны зардалд |
| Ажилчдын аюулгүй байдлыг хангах | Ажилтан ажилчдыг эрүүл мэндэд үзлэгт хамруулсан<br>Ажилд гарахын өмнө тогтмол эрүүл мэндийн үзлэгт оруулан зөвлөгөө өгч ажилуулсан<br>Ажилчдыг хувцас хэрэгслээр хангасан<br>Ажилчдын гэмтэл ослоос урьдчилан сэргийлэж заавар зөвлөгөө өгч хяналт тавьж ажилласан | Үйл ажиллагааны турш | 5800.0 |
| Ажилчдын аюулгүй байдлыг хангах | Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр / хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч , резинэн гутал , резинэн бээлий , хамгаалалтын нүдний шил маск, маск/ хангах | Үйл ажиллагааны турш | Үйл ажиллагааны зардалд |
| Гэнэтийн осол, гэмтэл, бэртлээс урьчилан сэргийлэх | Аюулын үед хэрхэн өөртөө болон бусдад туслах<br>Аюулгүй ажиллах нөхцөлийг хангаж ажилуулах | Төслийн талбайд үйл ажиллагааны турш | Үйл ажиллагааны зардалд |
| **Нийт дүн** | | | **6300,0** |

*Зураг 29*




*Гэнтийн осол эрслээс урьдчилан сэргийлэх сургалт*

*Зураг 30*



*Техник засвар үйлчилгээ*

*Зураг 31*




*Галын хор самбар*

*Зураг 32*



*Ажлын хувцас хэрэгсэл*

## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдал ус хоолны газар, усан орох газар , ариун цэврийн өрөө гэх мэтээс үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Хатуу хог хаягдал: Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд ахуйн хэрэглээнээс гарсан хуванцар сав, шил, лааз, цаас, сав баглаа боодол, асгарсан шатахуун, шатах тослох материалыг шингээж авсан цаас, алчуур, хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан зүйлс техник тоног төхөөрөмжийн хаягдал сэлбэг хэрэгсэл хаягдал төмөр утас гэх мэт зэрэг зүйлс, хатуу хог хаягдалд хамаарна.

Төсөл нийт 10 хүн ажиллах бөгөөд жилд 160 хоног өдөр ажиллана гэж тооцвол өдөрт 5 кг, сард 120кг, 10 хүн х 0,3 кг хатуу хог хаягдал /хоног х 30 хоног, жилд 90кг хог хаягдал гарах жилд 1500-1680кг ахуйн хог хаягдал гарах тооцоо байна. Энэ бол хүмүүсийн өдөр тутамын хэрэглээнээс гарах ахуйн хог хаягдлын тооцоо бөгөөд үүн дээр машин техникийн ШТМ, ашигласан тос маслын хаягдлыг тусгайлан хуримтлуулан жилд нэг удаа хаягдал тос, масло боловсруулах үйлвэрт нийлүүлнэ.

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх ахуйн хог хаягдлыг тусгай зориулалтын саванд ангилан ялгаж дахин ашиглаж боломжто эсэхээр нь хатуу хог хаягдалд зориулан барьсан хашаа, хайс хамгаалалтай цэг эсвэл байранд мал амьтан, орхооргүй, хөрс, усанд шууд шингэх боломжгүй байх хадгалсан бөгөөд Дэлгэрхангай сумын засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу төвлөрсөн хогын цэгт зайлуулж булшилдаг.Харин дахин ашиглах боломжтой хуванцар сав, шил, лааз, цаас болон хаягдал төмрийг ялган цууглуулж, хоёр дахь түүхий эд боловсруулах үйлдвэрт тушаахаар бэлдсэн.

Хатуу хог хаягдлыг эмх замбраагүй хаях, буруу, хадгалж, зайлуулсны улмаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох аргаар, ус, хөрс, ургамлан нөмрөгт бохирдуулагч бодис тархаж, улмаар ажилчид болон төслийн талбай орчмын иргэдийн эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж болзошгүйг онцгойлон анхаарах орчны цэвэрл эгээг тогтмол хийдэг.

Уурхайн үйл ажиллагааны явцад үүссэн хаягдалын бүтцийн судлан байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга, ажилтнуудад хог хаягдлын чиглэлээр сургалт явуулсан болно.

**Хог, хаягдлын менежментийн арга хэмжээ** *Хүснэгт 9*

| Болзошгүй сөрөг нөлөөлөл | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Нийт зардал мян.төгрөг |
|---|---|---|
| Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох | Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулаасан<br><br>нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх | Үйл ажиллагааны зардалд орсон |
| | 2024 оны хог хаягдалын гэрээ Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ЗДТГ-тай гэрээ байгуулсан.Хог хаягдлын төлбөрийг бүрэн төлсөн. | Үйл ажиллагааны зардалд орсон |
| Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй | Ариун цэврийн байгууламжийг байгальд ээлтэй байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн | 3000,0 |
| **НИЙТ ДҮН** | | **3000,0** |

“Ширээ Уул 2 гөлтгөний уурхайг ил уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал 1 жилд 3000.0 мян.төг болж байна.

*Зураг 33*



*ШТМ хадгалах цэг*

*Зураг 34*



*Хогийн цэг*

*Зураг 35*



*Ангилан ялгах хогийн цэг*

*Зураг 36*



*Эко  нойлын байгууламж*





## Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.1 дүгээр зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөлийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинэжилгээний хөтөлбөр гэж нэрлэх бөгөөд энэ төсөл нь хэрэгжиж буй үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний орон нутгийн захиргаа, байгууллага , нутгийн оршин суугчдад байгаль орчин амьдрах орчны өөрчлөлийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг дэвсгэрт байрлах MV-016920 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Ширээ Уул” 2 орд төслийг хэрэгжүүлэгч “Түмэн Цацал” ХХК-ний 2024 онд Дундговь аймгийн УЦУОШГ-ын лабортортт хийсэн

## Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

- Төслийн үйл ажиллагааны хүрээнд сөрөг нөлөөлөлийг бууруулах чиглэлээр зохион байгуулаж байгаа ажлууд нь агаарын тоосонцор, ус хөрсний бохирдлоос сэргийлэж бууруулахад байнга анхаарч хяналт тавиж ажилласан
- Мэргэжлийн байгууллагаар агаар ус хөрсний шинжилгээ хийлгэсэн
- Нутгийн иргэдэд агаар, ус , хөрсний чанарын үр дүнгийн талаар танилцуулах

**Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт хэрэгжүүлэхэд 1200,0 мян.төг болж байна.**

*Зураг 37* *Зураг 38* *Зураг 39* *Зураг 40*






*Агаар ус хөрсний шинжилгээ*

## УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН

Жил бүрийн гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажилсан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.

Орон нутгийн төр захиргааны болон бусад байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг заасан цаг хугацаанд нь биелүүлэж ажилласан.

Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах асуудлаар орон нутгийн төр захиргааны байгуллага болон эрх бүхий ажилтнуудтай байнга харилцан хамтарч ажилладаг.

**Удирдлага зохион байгуулалт** *Хүснэгт 10*

| Төсөвлөсөн арга хэмжээ | Гүйцэтгэл | Хамрах хүрээ | Нэгж үнэ сая.төг |
|---|---|---|---|
| Сум орон нутгийн хөгжилд | Орон нутгаас 2 хүнийг ажлын байраар хангах дадлагжуулан сургасан | Төслийн талбайд | |
| | Нутгийн иргэдээс мах сүү цагаан идээ авч өрхийн үйл ажиллагаа дэмжиж ажилсан | Дэлгэрхангай 2-р баг | 6940,0 |
| | Орон нутгийн Сумын төвийн үхсэн мал амьтаны сэг зэмийг нүх ухаш булшилж тэгшлэх ажил хийсэн | Дэлгэрхангай сумын төв дээр | 1000,0 |
| | Сум орон нутагийн Уул овооны тахилгат туслалцаа үзүүлсэн | Дэлгэрхангай 2-р баг | 540,0 |
| | малчин иргэдэд УБ өвс малын тэжээл өгсөн тээврийн зардлыг хөнгөлөж өгсөн | Сумын 2-р баг | 550,0 |
| | Сумын орон нутгийн иргэдэд БО хийгдсэн ажлаа тайлагнав | | |
| **Нийт зардалд** | | | **9,03** |

Удирдлага зохион байгуулалтын ажлын зардалд 9,03 сая төгрөг зарцуулав.

*Зураг 41* *Зураг 42*







*Дэлгэрхангай суумано зуданд үхсэн малын сэг зэмийг нүх ухаш булшилсан*

*Зураг 43* *Зураг 44*





*Сумын 2-р багийн нийтийн ажилд оролцсон*

*Малчидад тэжээлийн туслалцаа үзүүлсэн*





*Малчидад тэжээлийн туслалцаа үзүүлсэн*

**Орон нутгийн иргэдэд танилцуулга** *Хүснэгт 11*

| Д/Д | Төсөвлөсөн арга хэмжээ | Төсөв /мян.төг/ | Хэрэгжүүлэх хуваарь | | | Нийт зардал /мян.төг/ | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 4 сар | 5-6 сар | 7-9 сар | | |
| 1. | БОНБҮ болон БОХТ, ОХШХ-т заасан сөрөг нөлөөлөлийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | + | + | + | ОХШХ-н зардалд | 2024 оны ОХШХ-ийн тайланг БОАЖЯ-ны Байгаль орчны судалгаа шинжилгээний төв байгууллага хийж гүйцэтгэсэн. |
| 2. | Уурхайн нөхөн сэргээлтийн тайланг иргэдэд танилцуулах | | - | - | + | Үйл ажиллагааны зардалд | Багын хуралд таницуулав |



*Сумын 2-р багийн иргэдэд тайлан   тавьсан*